



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 9/242

Хэрлэн сум

“Монгол мал-II” арга хэмжээнд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Малын генетик нөөцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4.4, 8.4.5, 8.4.9, 11 дүгээр зүйлийн 11.1, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2 дугаар хуралдааны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар, 2023 оны 18 дугаар хуралдааны “Аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 02 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Монгол мал-II” арга хэмжээг хэрэгжүүлж, баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг ангилалт хийхэд шаардагдах 25,000,000 (хорин таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Зарцуулах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, ажлын гүйцэтгэлийг хянаж шалгах, үр дүнг танилцуулж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Ж.Энх-Амгалан)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Э.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
20 дугаар сарын 20...-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгур үзүүлэлт | Хөрөнгийн эх үүсвэр | 2023 онд шаардлагдах мөнгөн дүн /сая.төгрөг/ | Хариуцах газар хэлтэс |
|---|---|---|---------------------|--|-----------------------|
| 1 | "Галшар" Уулдрийн адгуунд үзлэг ангилалт хийнэ. | Галшар Уулдрийн 2,0 мянганадуунд үзлэг тун, стандартын шаардлага хангасан үйлдвэрлэн үндэсний генийн санд баяжилт хийсэн байна. | ОНТөсөв | 5,0 | ХХААГазар |
| 2 | "Галшар" Уулдрийн азарганы үрийг авч малын удмын сангийн үндэсний төвд хадгалуулах | Галшар Уулдрийн азарганы 1,0 мянган тун, стандартын шаардлага хангасан үйлдвэрлэн үндэсний генийн санд баяжилт хийсэн байна. | ОНТөсөв | 1,5 | ХХААГазар |
| 3 | Сургийн ямаанд үзлэг ангилалт судалгааны ажил хийнэ. | Галшарын улаан омгийн 5,0 мянган толгой ямаанд үзлэг ангилалт хийнэ. | ОНТөсөв | 7,5 | ХХААГазар |
| 4 | "Тал нутгийн цагаан" Уулдрийн хонинд үзлэг ангилалт хийж, дэмжлэг үзүүлэх байгуулах | Тал нутгийн цагаан Уулдрийн 400 толгой хонинд үзлэг ангилалт хийж, дэмжлэг үзүүлсэн байна. | ОНТөсөв | 5,6 | ХХААГазар |
| 5 | Эрчимжсэн аж ахуйн сургалт зохион байгуулах | Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр малчдын сургалт зохион байгуулсан байна. | ОНТөсөв | 5,0 | ХХААГазар |
| 6 | Малын зохиомол хээлтүүлийн техникич бэлтгэх сургалтад 1-ээс доошгүй мэргэжилтэн хамраулан мэргэжлийн чадамж олгох | Малын зохиомол хээлтүүлийн техникич 1-ээс доошгүй мэргэжилтэн хамрагдсан байна. | ОНТөсөв | 0,4 | ХХААГазар |
| | Дүн | | | 25,0 | |